

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Баянхонгор хот  
2022 оны 02 дугаар сар

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын  
Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат  
Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цээням  
Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа  
Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа  
Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.  
**Агуулга**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Төлбөрийн акт .....	16
4.2 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17

#### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,  
Баянхонгор аймаг, 64101  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.25 № 2/129

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

• 005020542

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

A handwritten signature in black ink, written over a faint red rectangular stamp. The signature is stylized and appears to be 'B. Mönkhbat'. The stamp contains some illegible text and numbers.

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>81,521,944.20</u></b>	<b><u>80,668,394.20</u></b>
33	АВЛАГА	9,950,000.00	00.00
335	Бусад авлага	9,950,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	9,950,000.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>71,571,944.20</b>	<b>80,668,394.20</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>29,267,336.00</b>	<b>34,616,686.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	27,857,686.00	27,857,686.00
35130	Эм боох материал	1,409,650.00	6,759,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>42,304,608.20</b>	<b>46,051,708.20</b>
35410	Бичиг хэргийн материал	100,000.00	100,000.00
35420	Аж ахуйн материал	15,992,007.80	17,605,607.80
35440	Түлш, шатах тослох материал	00.40	00.40
35470	Бусад хангамжийн материал	26,212,600.00	28,346,100.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,571,287,038.44</u></b>	<b><u>1,553,375,363.47</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,571,287,038.44</b>	<b>1,553,375,363.47</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,540,989,038.44</b>	<b>1,523,077,363.47</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,547,931,617.44	1,547,931,617.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-125,292,146.83	-186,208,925.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,006,269.00	10,006,269.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,006,269.00	-10,006,269.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	171,439,454.86	236,687,454.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-110,386,424.83	-132,670,192.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,594,976.00	98,408,976.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-46,994,032.20	-56,506,160.88
39217	Ном	14,695,594.00	15,434,594.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>30,298,000.00</b>	<b>30,298,000.00</b>
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,298,000.00	30,298,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,652,808,982.64</u></b>	<b><u>1,634,043,757.67</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>39,900.00</u></b>	<b><u>34,700.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>39,900.00</b>	<b>34,700.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>39,900.00</b>	<b>34,700.00</b>
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>39,900.00</b>	<b>34,700.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	39,900.00	34,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,652,769,082.64</u></b>	<b><u>1,634,009,057.67</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,652,769,082.64</b>	<b>1,634,009,057.67</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-20,015,937.56</b>	<b>-38,775,962.53</b>
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-18,760,024.97
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,652,808,982.64</u></b>	<b><u>1,634,043,757.67</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>905,670,669.00</b>	<b>805,902,510.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>88,162,505.00</b>	<b>46,433,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	88,162,505.00	46,433,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,162,505.00	46,433,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	784,500.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	87,378,005.00	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	00.00	41,888,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	00.00	4,545,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>817,508,164.00</b>	<b>759,469,510.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	675,290,900.00	646,962,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	675,290,900.00	646,962,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,341,764.00	19,999,939.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,711,364.00	19,999,939.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	630,400.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,875,500.00	92,507,071.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,875,500.00	92,507,071.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>896,801,512.09</b>	<b>824,662,534.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>896,801,512.09</b>	<b>824,662,534.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	803,255,658.83	785,641,169.59
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	491,150,869.40	490,411,514.54
210101	Үндсэн цалин	365,193,778.61	359,510,140.51
210102	Нэмэгдэл	59,789,800.00	93,990,470.39
210104	Урамшуулал	66,167,290.79	36,910,903.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,379,353.34	63,818,259.08
210201	Тэтгэврийн даатгал	41,309,311.17	43,624,857.42
210202	Тэтгэмжийн даатгал	5,050,339.00	5,383,261.42
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,026,074.00	3,949,370.74
210204	Ажилгүйдлийн даатгал	999,421.00	987,342.68
210205	Эрүүл мэндийн даатгал	9,994,208.17	9,873,426.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,911,528.00	91,513,811.00
210301	Гэрэл, цахилгаан	2,245,483.00	3,343,211.00
210302	Түлш, халаалт	86,291,045.00	87,757,900.00
210303	Цэвэр, бохир ус	375,000.00	412,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,396,079.20	7,395,410.00
210401	Бичиг хэрэг	1,651,700.00	1,193,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,251,740.00	1,299,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,322,200.00	2,163,900.00
210404	Ном, хэвлэл	00.00	269,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	639,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,829,500.00	2,289,400.00
210408	Бараа материал акталсны зардал	7,701,939.20	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	28,079,600.00	22,834,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,015,600.00	2,140,050.00

**Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210502	Хоол, хүнс	25,313,700.00	19,126,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,750,300.00	1,567,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,215,850.00</b>	<b>3,426,560.00</b>
210604	Урсгал засвар	4,215,850.00	3,426,560.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,136,000.00</b>	<b>344,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,136,000.00	344,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,507,300.00</b>	<b>7,447,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,057,300.00	6,707,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>107,479,078.89</b>	<b>98,449,714.97</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,820,950.00	3,945,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,435,100.00	1,791,540.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99,223,028.89	92,712,674.97
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,545,853.26</b>	<b>39,021,365.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,317,286.00</b>	<b>31,537,970.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,007,200.00	17,166,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,220,864.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,490,500.00	13,750,070.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,598,722.00	621,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,469,972.00</b>	<b>69.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,469,972.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,758,595.26</b>	<b>7,483,326.38</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,758,595.26	7,483,326.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>8,869,156.91</u></b>	<b><u>-18,760,024.97</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>363,150.76</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	363,150.76	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-363,150.76</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>8,506,006.15</u></b>	<b><u>-18,760,024.97</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	770,683,652.01	902,514,882.82	-3,801,892.55	1,669,396,642.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>770,683,652.01</b>	<b>902,514,882.82</b>	<b>-3,801,892.55</b>	<b>1,669,396,642.28</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-25,133,565.79	-25,133,565.79
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>770,683,652.01</b>	<b>902,101,368.19</b>	<b>-20,015,937.56</b>	<b>1,652,769,082.64</b>
<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>770,683,652.01</b>	<b>902,101,368.19</b>	<b>-20,015,937.56</b>	<b>1,652,769,082.64</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>770,683,652.01</b>	<b>902,101,368.19</b>	<b>-20,015,937.56</b>	<b>1,652,769,082.64</b>

**Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-18,760,024.97	-18,760,024.97
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>770,683,652.01</b>	<b>902,101,368.19</b>	<b>-38,775,962.53</b>	<b>1,634,009,057.67</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>818,292,664.00</b>	<b>759,469,510.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>784,500.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	784,500.00	00.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	784,500.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	784,500.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>817,508,164.00</b>	<b>759,469,510.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	675,290,900.00	646,962,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	47,341,764.00	19,999,939.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,711,364.00	19,999,939.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	630,400.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	94,875,500.00	92,507,071.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	94,875,500.00	92,507,071.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>793,407,264.00</b>	<b>736,506,510.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>793,407,264.00</b>	<b>736,506,510.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>699,861,510.74</b>	<b>697,485,144.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	486,684,295.74	489,507,764.06
210101	Үндсэн цалин	359,581,704.95	361,786,226.84
210102	Нэмэгдэл	59,789,800.00	91,128,360.87
210104	Урамшуулал	67,312,790.79	36,094,076.35
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	499,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,847,347.00	65,221,109.56
210201	Тэтгэврийн даатгал	47,210,247.00	46,888,599.12
210202	Тэтгэмжийн даатгал	4,743,200.00	4,613,210.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,642,000.00	3,661,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	939,600.00	902,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,312,300.00	9,155,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	88,911,528.00	91,513,811.00
210301	Гэрэл, цахилгаан	2,213,649.00	3,343,211.00
210302	Түлш, халаалт	86,291,045.00	87,757,900.00

**Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210303	Цэвэр, бохир ус	406,834.00	412,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,120,840.00</b>	<b>9,105,610.00</b>
210401	Бичиг хэрэг	1,651,700.00	1,193,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,251,740.00	1,299,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,322,200.00	2,138,900.00
210404	Ном, хэвлэл	00.00	294,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	639,000.00	1,180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,256,200.00	2,999,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>29,453,200.00</b>	<b>21,723,650.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,951,500.00	352,500.00
210502	Хоол, хүнс	25,313,600.00	19,132,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,188,100.00	2,239,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,647,850.00</b>	<b>5,479,760.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	300,000.00	2,240,000.00
210604	Урсгал засвар	4,347,850.00	3,239,760.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,136,000.00</b>	<b>344,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,136,000.00	344,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,507,300.00</b>	<b>7,447,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,057,300.00	6,707,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	500,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,553,150.00</b>	<b>7,141,540.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,820,950.00	5,350,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,732,200.00	1,791,540.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,545,753.26</b>	<b>39,021,365.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>60,317,186.00</b>	<b>31,537,970.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,007,200.00	17,166,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,220,864.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	21,490,500.00	13,750,070.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,598,622.00	621,200.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,469,972.00</b>	<b>69.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,469,972.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>29,758,595.26</b>	<b>7,483,326.38</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,758,595.26	7,483,326.38
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>24,885,400.00</b>	<b>22,963,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>24,885,400.00</b>	<b>22,963,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>24,885,400.00</b>	<b>22,963,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>24,885,400.00</b>	<b>22,963,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,885,400.00	22,963,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-24,885,400.00</b>	<b>-22,963,000.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	740,893,400.00	731,986,244.62	8,907,155.38	98.80
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	740,893,400.00	731,986,244.62	8,907,155.38	98.80
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	719,890,100.00	714,198,344.62	5,691,755.38	99.21
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	489,776,200.00	489,507,764.06	268,435.94	99.95
210101	Үндсэн цалин	383,799,300.00	361,786,226.84	22,013,073.16	94.26
210102	Нэмэгдэл	60,883,100.00	91,128,360.87	30,245,260.87	149.68
210104	Урамшуулал	45,093,800.00	36,094,076.35	8,999,723.65	80.04
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	499,100.00	-499,100.00	#DIV/0!
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,568,900.00	65,221,109.56	347,790.44	99.47
210201	Тэтгэврийн даатгал	46,941,800.00	46,888,599.12	53,200.88	99.89
210202	Тэтгэмжийн даатгал	4,656,700.00	4,613,210.44	43,489.56	99.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,725,500.00	3,661,700.00	63,800.00	98.29
210204	Ажилгүйдлийн даатгал	931,400.00	902,300.00	29,100.00	96.88
210205	Эрүүл мэндийн даатгал	9,313,500.00	9,155,300.00	158,200.00	98.30
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	92,930,900.00	91,513,811.00	1,417,089.00	98.48
210301	Гэрэл, цахилгаан	4,473,000.00	3,343,211.00	1,129,789.00	74.74
210302	Түлш, халаалт	87,757,900.00	87,757,900.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	412,700.00	287,300.00	58.96
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,172,900.00	9,844,610.00	328,290.00	96.77
210401	Бичиг хэрэг	1,193,000.00	1,193,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	1,300,000.00	1,299,410.00	590.00	99.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,405,600.00	2,138,900.00	266,700.00	88.91
210404	Ном, хэвлэл	1,034,600.00	1,033,700.00	900.00	99.91
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	1,240,000.00	1,180,000.00	60,000.00	95.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,999,700.00	2,999,600.00	100.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	24,564,500.00	21,723,650.00	2,840,850.00	88.44
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	958,500.00	352,500.00	606,000.00	36.78
210502	Хоол, хүнс	21,367,000.00	19,132,150.00	2,234,850.00	89.54
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,239,000.00	2,239,000.00	0.00	100.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	27,910,500.00	27,703,760.00	206,740.00	99.26
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,764,000.00	14,764,000.00	0.00	100.00
210602	Тавилга	9,900,000.00	9,700,000.00	200,000.00	97.98
210604	Урсгал засвар	3,246,500.00	3,239,760.00	6,740.00	99.79
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	455,600.00	344,000.00	111,600.00	75.50
210702	Дотоод албан томилолт	455,600.00	344,000.00	111,600.00	75.50
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,368,300.00	1,198,100.00	170,200.00	87.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	628,300.00	458,100.00	170,200.00	72.91

**Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	240,000.00	240,000.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7142300.00</b>	<b>7141540.00</b>	<b>760.00</b>	<b>99.99</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,350,000.00	5,350,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,792,300.00	1,791,540.00	760.00	99.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>21003300.00</b>	<b>17787900.00</b>	<b>3,215,400.00</b>	<b>84.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>21,003,300.00</b>	<b>17,787,900.00</b>	<b>3,215,400.00</b>	<b>84.69</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	20,382,100.00	17,166,700.00	3,215,400.00	84.22
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	621,200.00	621,200.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>740,893,400.00</b>	<b>731,986,244.62</b>	<b>8,907,155.38</b>	<b>98.80</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>646,962,500.00</b>	<b>639,479,173.62</b>	<b>7,483,326.38</b>	<b>98.84</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	646,962,500.00	639,479,173.62	7,483,326.38	98.84
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>93,930,900.00</b>	<b>92,507,071.00</b>	<b>1,423,829.00</b>	<b>98.48</b>
132001	Орон нутгийн төсвөөс	93,930,900.00	92,507,071.00	1,423,829.00	98.48
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>42.00</b>	<b>42.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	26.00	26.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	0.00	100.00
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>382.00</b>	<b>382.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	<b>382.00</b>	<b>382.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
630001	Төрийн өмчит ЕБС	382.00	382.00	0.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>42.00</b>	<b>42.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	27.00	27.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>19,999,870.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,999,870.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>19,999,870.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,249,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,249,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,750,070.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,750,070.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13,750,070.00

**Шинэжинст сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	19,999,939.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	19,999,939.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,999,939.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах, хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, ковидын тест олгосон анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах, Төсвийн тухай болон Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Ш.Даваацэрэн, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Х.Гантулга нар зурж, нярваар Ц.Ариунаа ажиллажээ.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль 2020-2021 оны хичээлийн жилд 43 орон тоотой, нийт 456 сурагчтайгаас өдрөөр 445 сурагч суралцсанаас бага анги 10 бүлгээр 274 хүүхэд, дунд анги 13 бүлгээр 169 хүүхэд суралцсан бол албан бус боловсролын сургалтаар 11 сурагч суралцсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг 2019 онд батлан мөрдөж байсан ба 2021 онд аймгийн ТЕЗ-ийн харьяаны байгууллагуудад мөрдөгдөх 300.0 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 896,801.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,968.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,174.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 824,662.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,246.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,597.3 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,634,043.8 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 18,765.2 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	81,521.9	80,668.4	(853.5)
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,950.0	-	(9,950.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	71,571.9	80,668.4	9,096.5
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	1,571,287.0	1,553,375.4	(17,911.7)
Үндсэн хөрөнгө	1,864,265.9	1,939,066.9	74,801.0
Хуримтлагдсан элэгдэл	(292,978.9)	(385,691.5)	(92,712.7)
Нийт хөрөнгө	1,652,809.0	1,634,043.8	(18,765.2)
Өр төлбөр	39.9	34.7	(5.2)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,652,769.1	1,634,009.1	(18,760.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,652,809.0	1,634,043.8	(18,765.2)

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд ухаалаг самбарын 9,950.0 мянган төгрөгийн авлагатай байсныг бүрэн барагдуулан хөрөнгийг орлогод бүртгэсэн байна.

Оны эхэнд 71,571.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 61,488.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 4,545.0 мянган төгрөгийн бараа материал авч, 56,420.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, оны эцэст 80,668.4 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй гарчээ.

Оны эхэнд бүртгэлтэй 1,864,265.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж өмнөх онд авлагыг барагдуулан 9,950.0 мянган төгрөгийн ухаалаг самбарыг авч, төсвийн хөрөнгөөр 22,963.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 41,888.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй ирснийг бүртгэн, оны эцэст 1,939,066.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 18,760.0 мянган төгрөгөөр нэмэгдэн 1,634,009.0 мянган төгрөг болсон байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, өмнөх үеийн үр дүн данс өөрчлөлт ороогүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль 2021 оны төсвийн төлөвлөлтийг 1,100,052.0 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71802, 71806 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийг анх 864,317.6 мянган төгрөгөөр баталж, 2021 оны 7 дугаар сард 908,519.2 мянга, 12 дугаар сард 908,519.2 мянга, 11 дүгээр сард 926,802.7 мянган төгрөг болж, анх батлагдсан төсвөөс 62,485.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Анхны батлагдсан төсөв	2021 оны 12 сард хийсэн тодотгосон төсөв
864,317.6	926,802.7

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургууль өөрийн орлогын төлөвлөгөөгүй, тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих 646,992.5 мянган төгрөгийг бүрэн авснаас 7,483.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, орон нутгийн санхүүжилтээс олгох тогтмол зардлын санхүүжилтэд батлагдсан 93,930.9 мянган төгрөгөөс 1,423,8 мянган төгрөг дутуу буюу 92,507.1 мянган төгрөгийг авч, нийт 731,986.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 19,999.9 мянган төгрөг төвлөрч зарцуулснаас 13,690.6 мянган төгрөг нь 5 багшийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, 4,300.0 мянган төгрөг нь "Боловсролын чанарын шинэчлэл" тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилт, 192,9 мянган төгрөг нь Боловсролын үнэлгээний төвийн шалгалтын бичиг хэргийн зардал, 1,577.5 мянган төгрөг нь түрээсийн сурах бичгийн үнэ байна.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шинэжинст сумын сургуулийн дотуур байрны хүүхдүүд 2021 оны 03 дугаар сард хоолны хордлого болж, тус хордлоготой холбоотой арга хэмжээний зардалд төсвөөс нийт 2,497.5 мянган төгрөгийг зарцуулсан байгааг цаашид анхаарч, зөрчлийг гаргахгүй байх, хяналтыг сайжруулах нь зүйтэй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд нийт 4 бүлэг зорилтын хүрээнд 54 арга хэмжээг төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг аймгийн БСУГ-аас 83% гэж дүгнэсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг шалгав.

Тус байгууллага нь 2021 онд нийт 948,515.2 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхээс шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлсэн боловч тушаал шийдвэрийг мэдээлэхдээ "Төрөл/хөрөнгө зарцуулах, ер авлага үүсгэх" хэсгийн мэдээллийг бүрэн оруулаагүй, шилэн дансны мэдээллийг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн шалгалтын мөрөөр засаж оруулснаас хугацаа хоцорч мэдээлсэн мэдээлэл нэлээд байгаа тул зөвлөмж өглөө.

### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,193.0 мянган төгрөгийг бүрэн зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.9 дэх "Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах"
2. Тогтмол зардалд 92,930.9 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 98.5 хувь буюу 91,513.8 мянган төгрөгийг зарцуулан тогтоолын 1.8 дахь "Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн боловч бүрэн биелүүлээгүй, тушаал оруулахдаа мэдээллийг бүрэн оруулаагүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Түлш шатах тослох материалын оны эхний үлдэгдлээр 0.4 төгрөгийн үлдэгдэл засагдахгүй байгааг санхүүгийн программын шинэчлэлтийг хариуцагч аж ахуйн нэгжид хандан зассан эсэхийг тулгах шаардлагатай байна.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,034.2 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн тайланд 77.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 470.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7,487.0 мянган төгрөгийн 4 зөрчилд менежментийн захидлаар 4 зөвлөмж хүргүүлэв.

##### 4.1 Залруулсан алдаа

Шинэжинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд дараах алдааг залруулав.

Сумын төрийн сангийн төлөөлөгч 2021.03.31-ний өдөр "Жаргалант энхмөнх" ХХК-д 571.0 мянган төгрөгийн эмийн үнийн эмийн зардлаас шилжүүлэх гүйлгээг дотуур байрны хүүхдийн хоолны зардлаас шилжүүлснээс тухайн зардлууд буруу илэрхийлэгдсэн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Мөнгөн гүйлгээний тайланд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг бууруулж, эмийн зардлыг нэмэгдүүлж залруулав.

##### 4.2 Төлбөрийн акт

Сургуулийн захирал Ш.Даваацэрэнд Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2021.05.19-ний өдрийн 05-03-009/11 дугаар актаар тус оны 03 дугаар сард хоолны хордлого болж эмчилгээнд хамрагдсан хүүхдүүдийн эмчилгээ, хоол, шатахууны 821,3 мянган төгрөгийн зардлыг төлүүлэх акт тогтоосон байхад төсвөөс 2021.06.22-ний өдөр 432.6 мянган төгрөгийг төлсөн мөн төсвийн хөрөнгөөр 37.5 мянган төгрөгийн хадаг худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвөөс төлсөн төлбөрийн актын 432.9 мянга, хадгийн үнийн 37.5 мянга, нийт 470.4 мянган төгрөгийг сургуулийн захирал Ш.Даваацэрэнгээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

##### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Зардлын холбоотой асуудал

1.1. **Илрүүлэлт:** Бичиг хэргийн зардалд батлагдсан батлагдсан 1,193.0 мянган төгрөгийг бүрэн зарцуулсан, тогтмол зардалд 92,930.9 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 98.5 хувь буюу 91,513.8 мянган төгрөгийг зарцуулан Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8, 1.9 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж, төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах

###### 2. Зардлын холбоотой асуудал

2.1. **Илрүүлэлт:** 2021 оны 9 дүгээр сард 3,160.5 мянган төгрөгийн эм боох материалыг 11 ширхэг шаардах хуудсаар олгохдоо байгууллагын даргаар цохолт хийлгээгүй, нярвын бэлтгэсэн тайланг нягтлан бодогч хянаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Байгууллагын удирдлагаас анхан шатны баримтын бүрдэлд тавих хяналтыг сайжруулах.

### 3. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт: Байгууллагын албан хаагчдад төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,543.5 мянган төгрөгийн бараа материалыг олгосон анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Албан хаагчдад бараа материалыг олгосон баримтыг албажуулан санхүүгийн баримтад хавсарган, нягтлан бодогч ажлын хариуцлагыг дээшлүүлэх

### 4. Дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт: Сургуулийн эмч 783.0 мянган төгрөгийн ковидын тестийн бүртгэлийг бүрэн хөтлөөгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулж, ковидын тест олгосон анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шинэжинст сумын сургууль	6	8,034.2	1	77.10	1	470.1	0	-	4	7,487.0

---oOo---